

Хонгил гаргах ажлын аюулгүй байдал (өндөр газрын ажил/ам)

(1) Хонгил дотор босоо ам барих ажил


Хонгил дотор босоо ам барих ажилд дараах зүйлүүд багтана. Үүнд:

- Ам руу, амнаас тоног төхөөрөмж, материал тээвэрлэх
- Үйлдвэрийн ажиллагаа

Босоо ам нь хэмжээгээрээ харилцан адилгүй бөгөөд ажлын агуулга хэмжээ ба барилгын нөхцлөөс хамаардаг. Материал ба тоног төхөөрөмж унах ба унагаахын эсрэг аюулгүйн арга хэмжээ маш чухал.


Босоо ам

Босоо амыг хонгилын уурхай юмуу зам руу хонгилын барилгын ажил хийхэд шаардлагатай материал ба тоног төхөөрөмжийг тээвэрлэхэд ашиглана. Хүнд жинтэй материал, тоног төхөөрөмжийг зам болон амаар дамжуулж зөөнө.



Үйлдвэрийн байгууламж

Үйлдвэрийн байгууламжууд нь хонгилын барилгын ажилд шаардлагатай зам бүхий байгууламжууд юм. Хонгилын доторлогооны хэсгүүдэд зориулсан малтсан хөрсийг хаях, хадгалах газар байдаг. Хонгилын барилгын ажлын үед тэдгээрийг угсарч задлах ба тоног төхөөрөмжийг ажиллуулах ажлыг хийнэ.



(2) Хүнийг унахаас хамгаалах систем (унахаас сэргийлсэн бэхэлгээ уяа)



1. Дараах тохиолдолд:

2м юмуу түүнээс өндөрт ажиллах үед унах эрсдэлтэй болсон үед Хүнийг унахаас хамгаалах систем (унахаас сэргийлсэн бэхэлгээ уяа) хэрэглэ.

2. Хүнийг унахаас хамгаалах системийн (унахаас сэргийлсэн бэхэлгээ уяа) төрөл

Хүнийг унахаас хамгаалах хоёр төрлийн систем (унахаас сэргийлсэн бэхэлгээ уяа) байдаг: бэлхүүсний бүстэй төрөл ба иж бүрэн бэхэлгээ уяа. Бэлхүүсний бүстэй төрөл нь унасан үед бие махбодид хүнд цохилт өгдөг учраас ерөнхийдөө "иж бүрэн бэхэлгээ уяаны төрлийг" ашиглана.

Хүн унахаас хамгаалах систем (Хүн унахаас хамгаалах иж бүрэн систем)




Бэлхүүсний бүсийн төрөл

3. Тусгай боловсрол эзэмших шаардлагатай.

Хүнийг унахаас хамгаалах систем (унахаас сэргийлсэн бэхэлгээ уяа) хэрэглэх үед, тухайн хэрэгслийн хэрэглээ зэрэг эрх зүй ба практик ур чадвартай холбоотой тусгай боловсрол эзэмших шаардлагатай.

(3) Нээлхийн ажлын аюулгүй байдал


Материал ба тоног төхөөрөмжийг ачих буулгах үед босоо аманд ойр ажиллаж байх үед задгайгаас унахаас болгоомжтой байх шаардлагатай.



1. Задгайгаас унахаас урьдчилан сэргийлэх


2м юмуу түүнээс дээш өндөртэй ажлын тавцангийн нээлхий юмуу ирмэгээс унах эрсдэлтэй газарт хаалт, бариул, халхавч заавал тавина.

Нээлхий нь газар дээрх хэсгүүдээс үл хязгаарлагдах бөгөөд босоо амын ажлын тавцанд хамаарна.



2. Нээлхийн цэг

Зөвшөөрөлгүйгээр бариулыг бүү ав. Ажлын шалтгаанаар үүнийг зайлшгүй авах шаардлагатай бол, ахлах ажилтнаас зөвшөөрөл авч, шаардлагагүй болсон үед өмнө байсан хэлбэрт нь даруй буцаана.




Нээлхийн бариул/дунд төмрийг авахын тулд хүнийг унахаас хамгаалах систем (унахаас сэргийлсэн бэхэлгээ уяа) шаардлагатай бөгөөд бариулаас хэзээ ч бүү дэгээдээрэй. Түүнээс гадна бариул юмуу дунд хөндлөвчийг шат болгон ашиглаж дээш доош бүү явуулаарай.

(4) Нисэх юмуу унах аюултай ажлын аюулгүй байдал

Нээлхийгээс материал унах, босоо амны доор ажиллаж байгаа ажилчинг цохих зэрэг осол гарсан. Хонгилын барилгын ажилд зөөвөрлөдөг материал ба тоног төхөөрөмжүүд нь том бөгөөд урт байдаг учраас нээлхийд хүрэх ба өлгөөстэй ачаа унаж тэнцвэр алдагдсаны улмаас осолд орох.

Материалыг ачиж буулгаж байх зуур нэрвтрэхийг хориглох бөгөөд дээд ба доод давхарт зэрэг бүү ажилла.

Урт зүйлийн хувьд ачааг унаж бутрахаас сэргийлэхийн тулд олс ашигла. Мөн нээлхий дээр ачааг тавих үед хүнийг унахаас хамгаалах системийг (унахаас сэргийлсэн бэхэлгээ уяа) хэрэглэнэ.



(5) Хүнд зүйл зөөвөрлөх аюулгүй байдал


Хонгил барих ажилд зөөвөрлөх олон зүйлүүд хүнд жинтэй байдаг.

- Хонгил нүхлэх машин болон төрөл бүрийн тоног төхөөрөмжийг зөөх ба тэдгээрийг босоо аманд зөөвөрлөх
- Хэсгүүд (хонгил доторлогооны хэсэг) хоолойг зөөвөрлөх оруулах ажил
- Ган төмөр бэхэлгээ ба ган хүрээг зөөвөрлөж оруудлан угсрах.
- Материалуудыг зөөж оруулах ба гаргах болон ба бусад ажлууд.



1. Татлагын ажлын гэрчилгээ

Краны өргөх ачаа нь 1 тонн юмуу түүнээс их байх үед жингээс хамаараад татлага ба бусад ажилд зориулсан "Татлагын ажиллагааны ур чадварын сургалт"-ыг дүүргэсэн ажиллуулна.




2. Татлагын ажил анхаарах зүйлүүд

Краны өлгөөстэй ачааны доор хэзээ ч бүү нэвтэр.

(6) Хийгээр таслах ажлын аюулгүй байдал.

Хийгээр таслах ажилд ган эд ангийн боловсруулахад ашигладаг. Хийгэр таслах ажлуудад, таслах ажлын явцад оч үүсэхээс сэргийлэхийн тулд ажилчны аюулгүй байдлаас гадна орчныг хатаана.



1. Хийгээр таслах тоног төхөөрөмж

Хүчилтөрөгч, ацетилен, пропан зэрэг хийнүүдээр өндөр даралттай хийн төмөр савыг дүүргэнэ. Савны өнгөний хувьд хүчилтөрөгчид хар, ацетилений хувьд хүрэн өнгөөр хамтатгасан байна.

2. хамгаалах төхөөрөмж

Ажилчид хамгаалалтын малгай, хамгаалалтын шил, амьсгалын хамгаалах аппарат, ажлын бээлийг өмсөх шаардлагатай.

3. Гэрчилгээ

Шатамхай хий болон хүчилтөрөгчийн холимогийг хэрэглэдэг учраас хийн гагнуур ба таслалт хийхийн тулд ажилчид "Хийн гагнуурын ур чадвар олгох сургалт"-ыг дүүргэсэн байна.


(7) Арк гагнуурын ажиллагааны аюулгүй байдал

Арк гагнуурыг ган төмөр материалыг гагнахын тулд хонгилын барилгын ажилд голдуу хэрэглэнэ.



1. Арк гагнуурын аппарат

Арк гагнуурын аппаратад гагнуурын аппарат, гар чийдэн, газардуулга орно.



2. Аюулгүй байдлын арга хэмжээ

Ажилчид хамгаалалтын малгай, хамгаалалтын шил, амьсгалын хамгаалах аппарат, ажлын бээлийг өмсөх шаардлагатай.

3. Гэрчилгээ

Арк гагнуурын ажил хийхдээ ажилчид "Арк гагнуурын тусгай боловсрол"-ыг эзэмшсэн байна.